



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 196

Улаанбаатар хот

**“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат
компанийн хэрэгжүүлж буй “Багахангай - Хөшигийн хөндий”
чиглэлийн төмөр замын төслийн хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөг батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 718 дугаар тогтоолын 1 дэх заалтад дараах нэмэлт оруулсугай.

1.1.“Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар” гэсний дараа “Монголын төмөр зам” ТӨХК-ийн хэрэгжүүлж буй Багахангай-Хөшигийн хөндийн чиглэлийн төмөр замын төслийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар” гэж;

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 718 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт болох “Монголын төмөр зам” ТӨХК-ийн хэрэгжүүлж буй Багахангай-Хөшигийн хөндийн чиглэлийн төмөр замын төслийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

3.Компанийн “Багахангай - Хөшигийн хөндий” чиглэлийн төмөр замын төслийн I үе шатны ажлын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (О.Батчулуун)-д үүрэг болгосугай.

4.Төслийн I үе шатны худалдан авах ажиллагааг тухай бүр Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлж, холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд нэмэлт өөрчлөлт оруулан зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (О.Батчулуун)-д даалгасугай.

5.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА




Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132000607
9-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн
19 дугаарын тогтоолын хавсралт



**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
БАГАХАНГАЙ- ХӨШИГИЙН ХӨНДИЙ ЧИГЛЭЛИЙН ДАГНАСАН ХЭРЭГЛЭЭНИЙ
САЛБАР ТӨМӨР ЗАМЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УРЬДЧИЛСАН ТӨСӨВ**

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ (мян.төг)	Нийт үнэ (мян.төг)
1	Газар чөлөөлөлтийн зардал	Га	90.12	19,115	1,722,641
2	Төмөр замын газар шорооны ажил	Км	76.74	4,547,792	349,017,358
3	Төмөрбетон гүүр	У/м	1500	89,922	134,883,493
4	Төмөрбетон хоолой	Ш	92.42	377,647	34,901,198
5	Төмөр замын дээд бүтцийн ажил	Км	120.94	1,947,061	235,481,647
6	Эрчим хүч хангамжийн зардал	Км	52.06	210,184	10,942,728
7	Барилга байгууламжийн зардал	М2	1166.48	3,125	3,645,214
8	Нарийвчилсан зураг төслийн зардал, 1%	%	1%	106,695	7,705,943
9	Захиалагчийн хяналтын зардал, 2%	%	2%	213,390	15,411,886
10	Техник технологийн хяналт, зөвлөх үйлчилгээний зардал	%	2%	213,390	15,411,886
11	Магадлашгүй ажлын зардал, 5%	%	5%	533,474	38,244,700
12	Норм, нормативын сан 0.4%	%	0.4%	42,678	3,082,377
	Нийт дүн				850,451,071.0

.....oOo.....